

2023.05.01

Дугаар 01/09

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 09.00 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, Бага тойруу 26/1 байр, 306 тоот өрөөнд боллоо.

Хуралд саналын эрхтэй нийт 70420 ширхэг энгийн хувьцааны 60309 ширхэг буюу нийт хувьцааны 85.64% хувийг эзэмшигч 4 хувьцаа эзэмшигч болох Д.Санжмятав - 24.47% /17239 ширхэг/, Я.Өлзий-утас - 20% /14072 ширхэг/, С.Амармандах - 22.6% /15917 ширхэг/, С.Энхмандах - 18.57% /13081 ширхэг/ нар өөрийн биеэр ирсэн байгаа тул "Компанийн тухай хууль"-ийн 69.1 дэх заалтыг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөрт тооцож байгааг хурлын дарга мэдээлэв.

Иймээс хэлэлцэх асуудлуудаа цаашид үргэлжлүүлэх нь зүйтэй гэж үзэж хурлыг зохих дэгийн дагуу үргэлжлүүллээ

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 02/02 дугаар тогтоолын дагуу энэ удаагийн хурлаар дараах батлагдсан асуудлуудыг хэлэлцэх болно.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Компанийн 2022 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийн тухай
2. Үйл ажиллагааны тайлангийн тухай
3. Компанийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний тухай
4. Компанид тулгамдаж буй санхүүгийн болон хуримтлагдсан өр зээлийн асуудлын шийдвэрлэх талаар
5. Төлөөлөн удирдах зөвлөлд шинээр нэр дэвшиж буй гишүүдийг сонгох, томилох тухай

Хурлын дарга Я. Өлзий-Утас: Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Монгол улсын Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 2 удаа зарлаж, мөн Монголын хөрөнгийн биржийн цахим хаягт байршуулсан болно.

Хурал зохион байгуулах комиссын даргын мэдэгдсэнээр энэ удаагийн хурлын ирц 85.64% хувьтай байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 69.1 дэх заалттай нийцэж байгаа тул хурлыг хүчин төгөлдөр гэж үзэн хурлаа үргэлжлүүлж, Компанийн 2022 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт болон тайлан, 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар гишүүдэд танилцуулж хэлэлцүүлээ.

Мөн компанийн санхүүгийн өнөөгийн нөхцөл байдал, ялангуяа хуримтлагдсан өр зээлийн асуудлуудыг шийдвэрлэх талаархи саналыг гүйцэтгэх захирал С. Амармандах дэлгэрэнгүй танилцууллаа.

Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдуулан хувьцаа эзэмшигч нар саналаа хэллээ.Үүнд :

ДЭВШИЛ МАНДАЛ ХК

Дундговь аймаг,
Сайнцагаан сум

Утас: 99300500

99095960

Дугаар _____

devshilmandal@outlook.com

Хувьцаа эзэмшигч Д.Санжмятав: Та бүгд компанийн хуримтлагдсан өр зээлийн асуудлыг шийдвэрлэх боломжийг судлаж, цаашид ямар гарц гаргалгаа байж болохыг ойрын үед танилцуулаач, санал солилцооч, шаардлагатай бол ээлжит бус хурал зарлаж, өр зээлийн асуудлуудыг тооцоо судалгаатай нухацтай ярилцах нь зүйтэй байна.

- Ээлжит хурлаар хэлэлцэж байгаа ажлуудын хэрэгжилтэнд цаашид анхаарч, ядахдаа мөнгө бага шаардах ажлуудыг нь хийж хэрэгжүүлэх нь зүйтэй байна

-Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр авсан судалгааны дагуу гаргасан боловч, холбогдох хууль журамд заагдсан бүртгэлийн хугацаанд цөөн хэдэн хувьцаа эзэмшигч л бүртгүүлээ.

Хувьцаа эзэмшигч Я.Өлзий-Утас : Үйл ажиллагаа явуулах боломжгүй учраас тус компанид банк санхүүгийн байгууллагууд зээл өгөх боломжгүй тул, шаардлагатай байгаа мөнгөн зарлагуудыг зөвхөн таньдаг хувь хүнээс хүүтэй зээлж буюу өөрийнхээ тэтгэврээс л илүүчлэн гаргаж байгаа олон жилийн бодит байдлыг хурлын тэмдэглэлд албан ёсоор тэмдэглүүлье.

Хувьцаа эзэмшигч С.Амармандах : Жил бүр бүртгэлийн хураамжууд, цалин хөлс, татвар, нийгмийн даатгал нэмэгдээд, өр зээлийн хүү болон үндсэн мөнгө нэхэгдээд хэцүү байна.

Компанийн хэлбэрийг өөрчилж, ХХК болгох боломжтой эсэх асуудлыг судлах хэрэгтэй байна. Өөр зүйлгүй гэснээр саналын асуудал түр дууслаа.

Та бүхний саналыг хүлээж авлаа. Энэ талаар нарийн тооцоо судалгаа хийж, цаг алдалгүй үйл хэрэг болгохыг шинээр сонгогдох төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагад үүрэг болгохоор тогтлоо.

Иймээс дээрх асуудлуудын талаар санал хураан Тооллогын комисс саналын хуудсаа хураагаад тооллогоо явуулья гэлээ.

Тооллогын комисс ажилдаа орж саналын хуудсыг тоолж дуусаад тооллогын комиссын дарга Г. Болор-Од Тооллогын комиссын тогтоолууд болон хурлын шийдвэрүүдийг уншиж танилцууллаа.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт батлах тухай /хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар/

2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай /хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар/

3.1. Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр дараах нэр бүхий гишүүдийг сонгох тухай /хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар/